

**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧААС ОЛОН НИЙТЭД
ХҮРГЭХ МЭДЭЭЛЛИЙН ЖУРАМ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Журмын зорилт

1.1 Энэхүү журмын зорилго нь үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд зайлшгүй хүргэх шаардлагатай мэдээлэл болон үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх бусад мэдээллийг тогтоосон хугацаанд олон нийтэд ил тод нээлттэй хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ

2.1 Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/ болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид Бирж гэх/-аас гаргасан журмын дагуу үнэт цаасаа Биржийн бүртгэлд бүртгүүлсэн үнэт цаас гаргагч, түүний Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн дарга ба гишүүн, компанийн эрх бүхий албан тушаалтан, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар энэ журмыг дагаж мөрдөнө.

2.2 Биржид давхар болон хоёрдогч бүртгэл хийлгэсэн гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй этгээдийн хувьд энэхүү журмыг дагаж мөрдөх хэдий ч Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасан хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэх боломжтой.

3 дугаар зүйл. Журмын нэр томъёоны тодорхойлолт

3.1 Энэхүү журамд тусгагдсан нэр томъёог Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хороо, Биржийн журамд заасан утгаар ойлгох ба тэдгээрт тайлбарлагдаагүй нэр томъёог дараах байдлаар ойлгоно.

3.2 “Бүртгэлтэй үнэт цаас гаргагч” гэж биржид үнэт цаасаа бүртгүүлсэн аливаа хуулийн этгээдийг ойлгох ба энэхүү журамд тусгасан үнэт цаас гаргагч, бүртгэлтэй хувьцаат компани, бүртгэлтэй компани гэх нэр томъёо нь ижил утга агуулгатай болно.

3.3 “Албан байдлаар харилцах” гэж энэхүү журмыг хэрэгжүүлэхэд оролцогч этгээдүүд нь хоорондоо харилцахдаа цаасан болон цахим хэлбэрээр албан бичиг, мэдэгдэл илгээхийг ойлгоно.

3.4 “Тогтвортой хөгжлийн менежмент” гэж компанийн бизнесийн болон дотоод үйл ажиллагааг тогтвортой хөгжил, үйлдвэрлэл, үйлчилгээний зарчмуудтай нийцүүлэхэд шаардлагатай удирдлагын систем (засаглал, бодлого, журам, хариуцсан ажилтан, сургалт, хяналт)-ийг цогцоор нь бүрдүүлэх тухай ойлгоно.

3.5 Журамд хоёрдмол утга гарсан тохиолдолд Бирж журмыг тайлбарлах эрхтэй байна.

3.6

ХОЁРДУГААР БҮЛЭГ. НИЙТЭД МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4 дүгээр зүйл. Бирж ба үнэт цаас гаргагчийн харилцаа

4.1 Үнэт цаас гаргагчаас ирүүлж буй албан мэдээлэл нь Монгол хэл дээр бичгэн болон тоон хэлбэрээр үйлдэгдэх ба шаардлагатай тохиолдолд, эсхүл сайн дурын үндсэн дээр мэдээллийг гадаад хэл дээр үйлдэж болно.

4.2 Компанийн цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээ баримтыг компанийн албан ёсны баримт бичигтэй адилтган үзнэ.

4.3 Утсаар (үүрэн болон суурин телефоноор) болон цахим шуудангаар харилцах тохиолдолд Биржээс шаардлагатай гэж үзвэл үнэт цаас гаргагчаас тухайн харилцааг нотлох буюу батлах баримт бичгийг шаардаж болно.

4.4 Бирж нь үнэт цаас гаргагчаас ирүүлсэн энэхүү журмын 4.3-т заасан хүсэлтийн хариуг хууль, тогтоомж, журам зааварт тогтоосон хугацаанд гаргаж, албан байдлаар эсхүл цахим хуудас, цахим хаягаар тус тус хүргүүлнэ.

4.5 Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн хүсэлтийн шинж чанар, ач холбогдол, цар хүрээ зэргээс хамаарч Бирж нь хариуг утсаар болон биечлэн уулзаж өгч болно.

4.6 Бирж нь өөрийн цахим хуудас болон цахим шуудангаар дамжуулан холбогдох этгээдэд аливаа мэдээлэл, мэдэгдэл, шаардлага, анхааруулга зэргийг хүргүүлж болох бөгөөд түүнийг албан харилцаа үүссэнд тооцно.

4.7 Үнэт цаас гаргагч нь нууцлалын шинж чанар өндөртэй, нууцыг хадгалах шаардлагатай мэдээллийг Биржид мэдэгдэхдээ, түүний нууцлалын түвшинд анхаарах шаардлагатайг албан бичигт дурьдсан байна.

4.8 Бирж нь хууль, тогтоомж, Хорооны журмын дагуу үнэт цаас гаргагчаас ирүүлсэн дотоод мэдээлэлд хамаарах зүйлсийн найдвартай байдлыг хангаж ажиллана.

4.9 Журмыг хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, хуулийн дагуу компанийн нууцад хамаарахаас бусад мэдээлэл нээлттэй, ил тод, бодитой, үнэн зөв, бүрэн гүйцэд, хоёрдмол утга агуулаагүй байх, мэдээллийг нийтэд хүргэх үйл ажиллагаа шуурхай байх зарчмыг баримтална.

4.10 Компаниас хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг хянах, хавтаст материалд хадгалах, бүртгэл хөтлөх, боловсруулах, түүнийг нийтийн хүртээл болгох ажлыг Биржийн Бүртгэл хариуцсан алба, нэгж хариуцна.

4.11 Мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг хадгалах ба мэдээллийн сангийн болон мэдээлэл хүлээн авах, түгээх үйл ажиллагааны аюулгүй, найдвартай байдлыг Биржийн Мэдээлэл технологи хариуцсан алба, нэгж хариуцна.

4.12 Үнэт цаас гаргагч нь Биржтэй “Бүртгэлийн гэрээ” байгуулах ба бүртгэлтэй байх хугацаандаа уг гэрээ болон түүнд орсон өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөх үүрэгтэй.

5 дугаар зүйл. Мэдээллийг нийтэд хүргэх

5.1 Үнэт цаас гаргагчийн мэдээллийг өөрийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах үүргийг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэх бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасны дагуу мэдээллийн үнэн зөвийг үнэт цаас гаргагч компани өөрөө бүрэн хариуцна.

5.2 Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилсон тухай шийдвэр болон анкетыг Биржид ажлын 3 хоногийн дотор ирүүлнэ. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь үнэт цаас гаргагчийн тогтмол биелүүлэх үүргийн хэрэгжилтийг хангах үндсэн чиг үүрэгтэй этгээд байна.

5.3 Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь дараах шаардлагыг хангасан байна:

- 5.3.1 Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байх;
 - 5.3.2 Хөрөнгийн зах зээлийн дүрэм, журмуудыг биелүүлэхэд шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах боломжтой байх;
 - 5.3.3 Ажлын цагаар харилцах боломжтой байх,
 - 5.3.4 Компанийн үндсэн ажилтан байх.
- 5.4 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь олон нийтэд хүргэх мэдээллийг компанийн болон Биржийн цахим хуудсанд байршуулна.
- 5.5 ТУЗ-ийн нарийн бичгийн даргад Биржийн цахим хуудаст хандаж мэдээ байршуулахад ашиглах нэр, нууц үг бүхий эрхийг Бирж олгоно.
- 5.6 Биржийн цахим хуудаст нэвтрэх эрхийг зориулалтын бусаар ашиглах, бусдад дамжуулах, санаатай болон санамсаргүй байдлаар бусдад олгохыг хориглох бөгөөд үүнээс үүдэх хариуцлагыг компанийн ТУЗ-ийн дарга хүлээнэ.
- 5.7 Компани энэ журамд заасан мэдээллийг нийтэд хүргэх харилцааг зохицуулсан дотоод журам баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж болно.
- 5.8 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлж байгаа эсэхэд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд тогтмол хяналт тавина.
- 5.9 Бирж нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар тархсан цуурхалтай холбоотой нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулан олон нийтэд хүргэж болно.
- 5.10 Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн аливаа мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлт оруулах болсон шалтгаан, тайлбарыг тодорхой бичиж, албан байдлаар ирүүлнэ.

6 дугаар зүйл. Үнэт цаас гаргагчийн цахим хуудас

- 6.1 Үнэт цаас гаргагч нь албан ёсны цахим хуудастай байх бөгөөд цахим хуудаст хувьцаа эзэмшигчдэд зориулсан цэстэй байна.
- 6.2 Үнэт цаас гаргагчийн цахим хуудас нь байнгын, идэвхтэй үйл ажиллагаатай байна.
- 6.3 Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй холбогдох хууль, журамд заасан мэдээ мэдээллийг өөрийн болон Биржийн цахим хуудаст нэгэн зэрэг мэдээлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

7 дугаар зүйл. Үнэт цаас гаргагчийн нийтэд мэдээлэх хугацаат мэдээлэл

- 7.1 Үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал нь жил, хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан хэлбэртэй байна. Үнэт цаас гаргагч жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, хагас жил, улирлын тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Биржид ирүүлнэ.
- 7.2 Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/-д нийцүүлэн үнэн зөв гаргаж жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 02 дугаар сарын 10-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайланг дараа сарын 20-ны дотор Биржид ирүүлнэ.

7.3 Хорооноос зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар баталгаажуулсан аудитлагдсан тайланг үнэт цаас гаргагч нь тайлант жил дууссанаас хойш 04 дүгээр сарын 01-ний дотор Биржийн цахим хуудаст байршуулж олон нийтэд мэдээлнэ.

7.4 Үнэт цаас гаргагч нь санхүү, үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг Хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дөрөвдүгээр хавсралтын маягт 1, маягт 2-ын дагуу ирүүлнэ. Үүнээс гадна доорх мэдээллийг жил, улирлын үйл ажиллагааны тайланд тусгаж ирүүлнэ.

7.5 Үнэт цаас гаргагчийн бүтэц /толгой, охин, хараат, зэргэлдээ компаниуд, тэдгээрийн хувь эзэмшлийн талаар/, холбоотой талуудын санхүүгийн гүйлгээний талаарх мэдээлэл

7.6 Үнэт цаас гаргагч нь /Банк, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллага, болон Үнэт цаасны компани/ төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг санхүүгийн тайлангийн хамт ирүүлнэ.

7.7 Үнэт цаас гаргагч нь КТХ-ийн 31.3, 61.1.3, 61.1.4-д заасан нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл

7.8 Тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо, ширхэг, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, үнэт цаасаар урамшуулал олгосон талаарх мэдээлэл

7.9 Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо ширхэг, хувь хэмжээний талаарх мэдээлэл

7.10 Үнэт цаас гаргагч нь сайн дурын үндсэн дээр байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны мэдээллийг хавсралт маягт 1-ийн дагуу гаргаж жилийн үйл ажиллагааны тайлангийн хамт жилд 1 удаа ирүүлж болно. (БОНЗ)-ын тайланд дараах асуудлуудыг багтаан тайлагнана. Үүнд:

7.10.1 Тогтвортой хөгжлийн менежмент системтэй холбоотой үзүүлэлтүүд гэдэгт тогтвортой хөгжлийн бодлого, бүтэц удирдлага, тайлагнал болон гишүүнчлэлтэй холбоотой асуудлууд;

7.10.2 Байгаль орчны үзүүлэлтүүд гэдэгт эрчим хүч, хүлэмжийн хий, уур амьсгалын өөрчлөлт, ус, хог хаягдал, биологийн төрөл зүйл зэрэг асуудлууд;

7.10.3 Нийгмийн үзүүлэлтүүд гэдэгт хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, жендэрийн эрх тэгш байдал, хүртээмж, олон нийтийн харилцаа, худалдан авалтын бодлого зэрэг асуудлууд;

7.10.4 Засаглалын үзүүлэлтүүд гэдэгт авилга, хээл хахууль, компанийн засаглал, комплаенс, оролцогч талуудын хамтын ажиллагаа зэрэг асуудлууд;

7.10.5 Салбарын үзүүлэлтүүд гэдэгт банк, санхүү, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, барилга, уул уурхай зэрэг салбарт үйл ажиллагааг явуулж буй үнэт цаас гаргагчдад тусгайлан хамаарах асуудлууд;

7.11 Хэрэв БОНЗ-ын үйл ажиллагааны тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг үнэт цаас гаргагчаас цуглуулах, танилцуулах боломжгүй бол энэ талаарх шалтгаан болон мэдээллийг цаашид ил тод болгох талаар авч буй арга хэмжээний талаар ‘тайлбар’ ирүүлнэ.

8 дугаар зүйл. Үнэт цаас гаргагчийн тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл

8.1 Үнэт цаас гаргагчийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлтүүд, өмч хөрөнгийн болон удирдлага зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой мэдээллийг ажлын 2 хоногт багтаан ирүүлж, нийтэд мэдээлэх үүрэгтэй.

8.2 Үнэт цаас гаргагч нь санхүү, үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг Хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дөрөвдүгээр хавсралтын дөрөвт заасан мэдээллийг тухай бүр ирүүлнэ.

8.3 Үнэт цаас гаргагчаас тухай бүр нийтэд хүргэх дээрх мэдээллээс гадна доорх мэдээллийг ирүүлнэ.Үүнд:

8.3.1 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны үнэ ханшид болон компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрүүд;

8.3.2 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаарт өөрчлөлт орсон;

8.3.3 Нийт ажиллагсдын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орсон талаарх мэдээлэл;

8.3.4 Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл болон тэдгээрийн бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд гарсан өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

8.3.5 Үнэт цаас гаргагчийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурийн талаарх мэдээлэл, түүнд орсон өөрчлөлт

8.3.6 Үнэт цаас гаргагчийн охин, хараат компаниудын үйл ажиллагаатай холбоотой аливаа тусгай зөвшөөрөл эзэмших болсон эсхүл түүний хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл;

8.3.7 Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл /лиценз/,бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болгосон талаарх мэдээлэл;

8.3.8 Үнэт цаас гаргагч нь өөрийн үнэт цаасаа эргүүлэн худалдан авах, худалдан авсан хувьцаагаа бусдад шилжүүлэх, эргэлтэнд гаргах тухай шийдвэрийг ирүүлнэ. Шийдвэрт үнэт цаасыг худалдан авах /худалдах/ зорилго, авах /эргэлтэнд гаргах/ хувьцааны тоо, үнэ, нийт хувьцаанд эзлэх хувь, төлбөр хийх хугацааны талаар тусгана.

8.3.9 Хууль тогтоомж, СЗХ-ны холбогдох журамд заасан бусад мэдээлэл

9 дүгээр зүйл. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл

9.1 Үнэт цаас гаргагч нь их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл, их хэмжээний бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг ирүүлнэ.

9.2 Компанийн тайлант хугацаанд хийсэн хэлцэл нь тухайн иргэн болон хуулийн этгээдтэй хийсэн хэлцлүүд нийт дүнгээрээ нэмж тооцогдох бөгөөд КТХ-ийн 87.1-д зааснаас хэтрэхгүй байна.

10 дугаар зүйл. Шинээр болон нэмж үнэт цаас гаргасан компаниудаас ирүүлэх мэдээлэл

10.1 Олон нийтээс татсан хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг бүрэн хэрэгжүүлэх хүртэл хугацаанд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, төслийн гүйцэтгэлийн тайланг улирал тутамд гаргаж, дараа сарын 15-ны дотор Биржид ирүүлнэ.

10.2 Өрийн хэрэгсэл гаргасан бол Хорооны “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 8-д заасан мэдээллийг Биржид ирүүлнэ.

10.3 Шинээр болон нэмж үнэт цаас гаргасан үнэт цаас гаргагчийн төслийн явцтай газар дээр очиж хяналт, шалгалтыг Гүйцэтгэх захирлын удирдамжийн дагуу хийж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

11 дүгээр зүйл Хариуцлагын арга хэмжээ

11.1 Үнэт цаас гаргагч нь энэхүү журам болон Бүртгэлийн гэрээг зөрчсөн, эсхүл хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.

11.2 Үнэт цаас гаргагчид дараах хэлбэрийн хариуцлагыг тооцно.

11.2.1 анхааруулах,

11.2.2 гэрээний хариуцлага ногдуулах;

11.2.3 Үнэт цаасны ангилал бууруулж бүртгэх;

11.2.4 Нэмж үнэт цаас бүртгэх эрхийг хязгаарлах;

11.2.5 Үнэт цаасны арилжаа зогсоох саналыг Хороонд хүргүүлэх;

11.2.6 Үнэт цаасыг бүртгэлээс хасах;

11.3 Журмын 11.2-д заасан зөрчлийн дагуу анхааруулга авсан үнэт цаас гаргагч нь зөрчлийг арилгах төлөвлөгөө, зөрчлийг арилгасан тухай тайланг заасан хугацаанд ирүүлэх үүрэгтэй.

11.4 Анхааруулах арга хэмжээг цаасаар болон цахим хэлбэрээр хүргүүлж болно.

11.5 Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн тайлан, тайлбар, хэрэгжүүлсэн арга хэмжээг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд Бирж нь нэмэлт тайлбар, тодруулга ирүүлэхийг шаардаж болно.

11.6 Үнэт цаас гаргагчид ногдуулсан хариуцлагын арга хэмжээ, түүний шалтгаан болон хэрэгжилтийн талаар Бирж өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

11.7 Үнэт цаас гаргагчийн гаргасан зөрчлийг харгалзан дээрх хариуцлагын хэлбэрүүдийг заавал шат дараалан оногдуулахгүй байж болно.

11.8 Биржээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үнэт цаас гаргагчийн ажлын байранд газар дээрх шалгалтыг хийж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

12 дугаар зүйл Маргаан шийдвэрлэх

12.1 Үнэт цаас гаргагч нь Биржээс үнэт цаас гаргагчтай холбоотой буюу Бирж болон Хороонд бүртгэлтэй үнэт цаастай холбоотойгоор гаргасан аливаа мэдэгдэл, шийдвэрийг эс зөвшөөрвөл мэдэгдэл шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш ажлын 10

өдрийн дотор холбогдох эрх бүхий этгээдэд гомдол гаргаж болно. Заасан хугацаанд гомдол гаргаагүй тохиолдолд шийдвэрийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.